

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА ЦАГДААГИЙН ХУРАНДАА




Ө.ЭНХТӨР

ШАТАХУУН БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

БАТЛАВ

"ПЕТРО СТАР" ХХК-НИЙ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

 Б.ЭНХ-АМГАЛАН

2017 оны 06 дугаар сарын 05 өдөр

PS 2017/а/10

Улаанбаатар хот

№ 08/06/17 02/17/51

Энэхүү гэрээг нэг талаас "Петростар" ХХК-ийг төлөөлж байгууллага хариуцсан ахлах менежер Э.Мөнхсүх, /цаашид нийлүүлэгч гэх/, нөгөө талаас "Цагдаагийн Ерөнхий Газрыг" төлөөлж Санхүү аж ахуйн албаны дарга, цагдаагийн хурандаа У.Энхтөр /цаашид худалдан авагч гэх/, хамтад нь талууд гэх, дараахи нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

1. Гэрээний зүйл

1. Монгол улсын иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон Нийлүүлэгч, Худалдан авагч нарын хооронд үүсэх харилцааг зохицуулах харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Худалдан авагч нь шатахууны (Цаашид бараа гэх) гэрээний үнийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний 2,921,863,000 /хоёр тэрбум есөн зуун хорин нэгэн сая найман зуун жаран гурван мянга/ төгрөгийн үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Барааг худалдан авахдаа "Петростар" ХХК-ийн шатахууны картаар гүйлгээг хийж болно.
5. Нийлүүлэгч нь хавсралтанд дурьдсан шатахууны нэр, төрлийн барааг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн дотор нийлүүлднэ.
6. Шатахуун нийлүүлэх жагсаалтыг гэрээний хавсралтад тусгана.

2. Худалдагчийн үүрэг

1. Худалдагч нь Худалдан авагчид Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанар стандартын шаардлага хангасан шатахууныг, "Шатахуун түгээх станц" гэсэн нөхцлөөр худалдан авагчид худалдахаар тохиролцов.
2. Худалдагч нь шатахууныг Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх бүх Шатахуун түгээх станцаар, Орон нутаг дэх бүх холбогдох Шатахуун түгээх станцаар чанарын шаардлага бүрэн хангасан шатахууныг Петровис картын үйлчилгээг сонгож болно.



3. Худалдагч нь А-80 маркийн шатахууныг "Говь" ХК-ний зүүн талд байрлах Шатахуун түгээх станцад олгоно.

3. Худалдан авагчийн үүрэг

1. Худалдан авагч нь шатахуун хүлээн авах албан тушаалтны нэр гарын үсгийн баталгааг албан бичгээр Нийлүүлэгчид өгөх ба энэ нь гэрээний нэг хэсэг болно.
2. Худалдан авагчид нийлүүлсэн шатахууны хэмжээ нь картын баримт гүйлгээгээр тодорхойлогдох бөгөөд задаргаа тайлан тооцоог тухай бүр авч болно.
3. Худалдан авагчийн эрх бүхий албан тушаалтан нь худалдан авсан шатахууны тооцоог сар бүрийн эцэст нийлүүлэгчийн нягтлан бодогчтой тооцоо нийлж акт үйлдэн баталгаажуулна.
4. Гэрээнд шатахуун авах машины жагсаалтыг, авах тоо хэмжээг заасан байгууллагын баримтыг хавсаргана.

4. Төлбөрийн нөхцөл, хариуцлага

1. Нийлүүлэгч нь худалдан авагчид авсан шатахууны тооцоог нэр төрөл, тоо хэмжээ, үнийн дүнг харилцан тохиролцсон хугацааны дагуу нэхэмжлэх ба төлбөрийг ажлын 7 хоногийн дотор багтаан төлсөн байна.
2. Гэрээний үнэ нь ТӨБЗГ-2017/ЭШ-02 дугаар бүхий тендерийн багцын үнэ байна.
3. Төлбөрийг нэхэмжлэхийн дагуу хугацаандаа төлөөгүй тохиолдолд хоногт 0,05% хүртэл алданги ноогдуулж тооцно.
4. Гэрээний явцад үнэ тогтмол байна.

5. Барааны чанар

1. Нийлүүлсэн бүтээгдэхүүний чанар нь ОХУ-д мөрдөгддөг ГОСТ болон техникийн нөхцөлд тохирсон байна.
2. Нийлүүлсэн бүтээгдэхүүнд Толгойт агуулахын шатахууны лабораторын чанарын паспортоор баталгаажигдана.

6. Бусад зүйл

1. Хоёр тал гэрээний биелэлтийг дүгнэж баталгаажуулна.
2. Энэхүү гэрээний явцад гарсан маргааныг талууд харилцан хэлэлцэж шийдвэрлэх бөгөөд хэрэв чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.
3. Давагдашгүй хүчин зүйл гарч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болбол гэрээний хугацааг 2 сар хүртэл хугацаагаар сунгана. Давагдашгүй хүчин зүйлд байгалийн гамшиг, газар хөдлөлт үер ус, дайн байлдаан, экспорт импортын хориг, дээд газрын шийдвэр гэх мэт хамаарагдана.
4. Гэрээнд оруулах аливаа нэг засвар нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид албан ёсоор баталгаажуулсан байна.
5. Гэрээг 4 хувь үйлдэх бөгөөд хувиуд нь хуулийн адил тэнцүү эрхтэй байна.



Цагдаагийн ерөнхий газрын даргын
2017 оны 08 дугаар сарын 27 ны
өдрийн 4/17 дугаар тушаалын
хавсралт

ОРЛОГОД АВАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Автомашины марк	Үйлдвэр лэсэн он, улс	Арлын дугаар	Хөдөлгүүрийн дугаар	Өнгө	Тоо, ширхэг	Автомашины үнэ
1	"Хьюндай соната LF"	2016, БНСУ	КМНЕ241САГА258753	G4NAGA524844	хар	1	61,000,000.00
2	"Хьюндай соната LF"	2016, БНСУ	КМНЕ241САГА258767	G4NAGA524846	хар	1	60,000,000.00
3	"Хьюндай соната LF"	2017, БНСУ	КМНЕ241СВНА357449	G4NANA608449	хар	1	61,000,000.00
Дүн:						3	182,000,000.00

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

6 Гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлахгүй бөгөөд хэрэв гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзвал түүнтэй холбогдож гарах бүх зардлыг буруутай тал нь бүрэн хариуцна

ХЯНАСАН.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны
Санхүүгийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

Н.Алтансүх

Худалдан авагчийг төлөөлж:

ЦЕГ-ЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

У.ЭНХТӨР

САНХҮҮ, САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ
ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН, ЦАГДААГИЙН ДЭД
ХУРАНДАА

Б.ЦЭНДБАЯР

Нийлүүлэгч талыг төлөөлж:

"ПЕТРОВИС ОЙЛ" ХХК-ИЙН
САНХҮҮ ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ

Ц.СЭРГЭЛЭН

"ПЕТРОСТАР" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.ХАТАНБҮҮВЭЙ

"ПЕТРОСТАР" ХХК-ИЙН
БОРЛУУЛАЛТЫН АХЛАХ
МЕНЕЖЕР

Д.МӨНХ-ОД

"ПЕТРОСТАР" ХХК-ИЙН
БАЙГУУЛЛАГА ХАРИУЦСАН
АХЛАХ МЕНЕЖЕР

Э.МӨНХСҮХ

"ПЕТРОСТАР" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Ц.НАРАНТУЯА

ХУУЛЬЧ

Д.ТЭМҮҮЖИН

Улаанбаатар хотын Чингэлтэй
дүүргийн Самбуугийн гудамж-18
ЦЕГазар оффис, 6-р давхар 604
тоот
Утас: 70118664
Факс: 70111873

Ерөнхий сайд Амарын гудамж
7, Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот
Утас 330909, 88112735
Факс: 311593
Данс: Голомт Банк 1103025864
ХХБанк 499137428

(85,916,500)
(5,000,000)

2017 оны _____ дугаар сарын _____ ний
өдрийн 2017/01/13 дугаар гэрээний хавсралт

УЛААНБААТАР ХҮРЭЭНИЙ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД 2017-2018 ОНД
БЭЛТГЭХ ШАТАХУУНЫ ЖАГСААЛТ ҮНИЙН ХУВААРЬ

№	Багц	Шатахуун, тослох материалын нэр	Хэмжих нэгж	Нийт тоо /литр/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Багц-1	А-80	Литр	80,000	1430	114,400,000
2		АИ-92	Литр	630,000	1575	992,250,000
3		ДТ	Литр	93,200	1670	155,644,000
Дүн:						1,262,294,000
4	Багц-2	А-80	Литр	110,000	1430	157,300,000
5		АИ-92	Литр	855,000	1575	1,346,625,000
6		ДТ	Литр	93,200	1670	155,644,000
Дүн:						1,659,569,000
Нийт дүн:						2,921,863,000

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

"ПЕТРОСТАР" ХХКОМПАНИ